



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 01

Мааньт

Малын тоо толгойн албан татварын
хэмжээг тогтоох тухай

Сумын малын тоо толгойн албан татварын хэмжээ тогтоох тухай Засаг дарга М.МөнхЭрдэнийн хуралд өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг сонсож хэлэлцээд Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “д”, 18.2, 22 дугаар зүйлийн 22.1.10, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Малчин, мал бүхий этгээдийн нэг толгой малд ногдуулах албан татварын хэмжээг дор дурьдсанаар тогтоосугай.

Үүнд:

Тэмээ	0 төгрөг
Адуу	500 төгрөг
Үхэр	500 төгрөг
Хонь	200 төгрөг
Ямаа	200 төгрөг

Хоёр. Малын тоо толгойд ногдуулсан албан татварыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэн Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7.1-д заасан хугацаанд төлүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

Гурав. Малын тоо толгойн албан татварын тухай хууль, энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, малын тоо толгойн албан татварын орлогыг сумын 2021 оны төсөвт тусган батлуулах, сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэн Төсвийн тухай хуулийн

60 дугаар зүйлийн 60.2.8-д заасан зориулалтаар зохих журмын дагуу зарцуулах, иргэдэд сургалчлан ажиллахыг сумын Засаг дарга /М.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

Дөрөв. “Малын тоо толгойн албан татвар тогтоох тухай” тогтоолыг Хууль зүй дотоод хэргийн яамд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэн мөрдүүлэх арга хэмжээ авахыг Иргэдийн хурлын Төлөөлөгчдийн нарийн бичгийн дарга /Г.Урангоо/-д даалгасугай.

Тав. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Л.БАТСУУРЬ